

АССИТЕЖ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2023-2025



ASSITEJ MONGOLIA

АССИТЕЖ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТУХАЙ

АССИТЕЖ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТӨВ НЬ АССИТЕЖ ОЛОН УЛСЫН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН ТЕАТРЫН ХОЛБООНЫ МОНГОЛ ДАХ ҮНДЭСНИЙ ТӨВ БӨГӨӨД НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ, АШГИЙН БУС ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ЮМ.

АССИТЕЖ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТӨВ НЬ УРЛАГИЙН БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДОЛЫГ ОЙЛГОДОГ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛТЭЙ, ЭНЭ САЛБАРТ АЖИЛЛАДАГ, ДЭМЖДЭГ ХУВЬ ХҮН, БАЙГУУЛЛАГУУД ГИШҮҮНЭЭР НЭГДЭХ БОЛОМЖТОЙ ХОЛБОО ТУЛ ХАМГИЙН ЧУХАЛ ХЭСЭГ НЬ ГИШҮҮД БАЙНА. ГИШҮҮН БОЛСНООР ХҮСЭЛ СОНИРХОЛ АДИЛ ХҮМҮҮСТЭЙ ХАМТДАА ХӨГЖИЖ, МОНГОЛЫН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН УРЛАГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ БОЛОМЖТОЙ БОЛОХ ЮМ

Алсын хараа:

Монгол улсын бүх хүүхэд залуучуудад хүртээмжтэй, чанартай тайзны урлагийг хүргэснээр энэрэнгүй, бүтээлч, ухамсарт иргэдийг бий болгоно.

Эрхэм зорилго:

Монгол улсын бүх хүүхэд залуучуудад тайзны урлагийг хүртээмжтэй байлгахад олон төрлийн арга хэрэгслийг нэвтрүүлэх, тайзны урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүмүүсийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, дотоодын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөн тайзны урлагийн ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах.





ASSITEJ MONGOLIA

Бидний үнэт зүйл



Community/Хотол: Бие биеэ дэмждэг, хүнлэг, зөв хандлагатай хамт олон байж, хүн бүр оролцох, өөрийнхөөрөө байх боломжтой аюулгүй орчинг бүрдүүлж, мэдлэг туршлагаа хуваалцаж, хамтын түншлэлээр бодит үр дүнг бий болгоно.



Хамтын ажиллагаа: Хамтаараа бид илүү хүчтэй.



Тэгш хүртээмж: Нас хүйс, үндэс угсаа, эрүүл мэндийн байдал, арьс өнгө, улс төрийн болон шашин шүтлэгийн итгэл үнэмшил, мэргэжлийн чадавх, бэлгийн чиг хандлага, соёлын ялгаа зэргээс үл хамаарч хувь хүн болон байгууллагууд нэгдэх эрхтэй.



Суралцахуй: Бүтээлч байдлаа байнга хөгөлж, ирээдүй хойч үедээ үлгэрлэж, тогтмол өөрсдийгөө сайжруулах, хөгжүүлэх хандлагатай байх.





ASSITEJ MONGOLIA

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ 2021/2025

Удирдах Зөвлөл
Салбар бүрийн
туршлага,
ур чадвартай 13
гишүүдээс
бүрдэж байна.

Гүйцэтгэх Захиралаар
Т.Цэнд-Аюуш
сонгогдож
АССИТЕЖ Монгол
Үндэсний
Төвийн өдөр тутмын
үйл
ажиллагаа,
хөтөлбөрийг
хариуцан ажиллаж
байна.

Сайн
дурынхан
(Volunteers)

АССИТЕЖ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ТӨВИЙГ БАЙГУУЛАХ САНААЧЛАГЫГ БАМБҮҮ ТЕАТРЫН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ А.УЯНГА ГАРГАЖ, МОНГОЛ УЛСЫН УРЛАГЫН ЗӨВЛӨЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТРТАЙ ХАМТРАН ҮҮСГЭН БАЙГУУЛЖ УДИРДАХ ЗӨВЛӨЛТЭЙ БОЛОХ ШИЙДВЭРИЙГ ГАРГАСАН. 2021 ОНЫ 6 САРЫН 28-НЫ ӨДӨР АЛБАН ЁСООР АНХНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛАА ХИЙЖ НИЙТ 13 ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨ БҮРДҮҮЛСЭН. БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨХ ДҮРМИЙГ ЭНЭ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАВ.





ASSITEJ MONGOLIA

2



БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ 2023-2025



А.Уянга
Бүтээлч Бамбүү
төвийн үүсгэн
байгуулагч,
АССИТЕЖ Монгол
Үндэсний Төвийн УЗ
тэргүүн



О.Одгэрэл
Монголын Урлагийн
Зөвлөлийн Гүйцэтгэх
Захирал, АССИТЕЖ
Монгол Үндэсний
Төвийн УЗ дэд
тэргүүн



Б. Анар
IARUDI ХХК санхүү
татварын зөвлөх
үйлчилгээний
компаний Ахлах
Менежер, АССИТЕЖ
Монгол Үндэсний
Төвийн санхүүч



А.Энхгэрэл МОНГОЛ
БАЗАЛЫТ ХК-ийн
Гүйцэтгэх захирал



М.Отгончимэг
Монгол Улсын
Хүүхэлдэйн
Театрийн Гүйцэтгэх
Захирал



Б.Энхбат
ХаанЛекс Партнерс
хуулийн фермд
Хуульч өмгөөлөгч,
Монголын Урлагийн
Зөвлөлийн Удирдах
Зөвлөлийн гишүүн



Б.О.Оюунтуяа
ХБНГУ-д суугаа
Монгол Улсын
Соёлын элч



А.Дөлгөөн
Сентрал ТВ дэд
захирал



Ө.Буянхишиг
Арт оф УБ галлерейн
үүсгэн байгуулагч



Б.Номин
Трий Хаус гэр
бүлийн кафений
үүсгэн байгуулагч



Төрмөнх
Бүтээлч Бамбүү
төвийн Гүйцэтгэх
Захирал



Ч.Уранхолбоо
“Хөөрхөн дэлхий
ТББ”-ын тэргүүн




З.Өлзийбат
АССИТЕЖ Монгол
Үндэсний төвийн
Нарийн бичгийн
дарга



Т.Цэнд-Аюуш
АССИТЕЖ Монгол
Үндэсний төвийн
Гүйцэтгэх Захирал

4



Стратегийн зорилго 1
Хүртээмжтэй болгох

Стратегийн зорилго 2
Уран бүтээлчдийг
бэлтгэх, хөгжүүлэх,
дэмжих

Стратегийн зорилго 3
Хамтын ажиллагаа

Стратегийн зорилго 4
Олон нийтэд
сурталчлах

МАНАЙ ГИШҮҮД



2021-2022 ОН

ГОЛЛОН ХИЙГДСЭН АЖИЛ

1.ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ:

Олон Улсын АССИТЕЖ-ээс зохион байгуулсан нетворкинг цахим уулзалтуудад нийт 6 удаа (2 удаа Coffee session, 2 удаа Umbrella meeting, 1 удаа ASSITEJ Small size, 1 удаа ASSITEJ USA webinar) Үндэсний төвөө төлөөлөн оролцсон ба ASSITEJ USA, ASSITEJ South Africa нартай цахимаар, ASSITEJ Switzerland үндэсний төвтэй биетээр уулзаж туршлага судаллаа.

ASSITEJ World Congress 2021 Мираи фестивалийн үзвэр, вэбинарыг нийслэлийн болон орон нутгийн хүүхдийн театрууддаа хүргэж чадсан билээ. Энэхүү уулзалт нь 2 жил тутамд 60 гаруй орны төлөөлөгчдийг хамруулан дараагийн 2 жилийн төлөвлөгөөгөө ярилцаж, тулгарч буй асуудлаа уваалцан шийдлээ ололцдог хамгийн том чуулган юм.

2021 онд дээрх арга хэмжээнд оролцсон Монгол Улсын Хүүхэлдэйн театр болон орон нутгийн театрууд болох Тэмүжин театр (Баянхонгор аймаг), Хүүхэд залуучуудын театр (Орхон аймаг), Саранхөхөө театр (Дорноговь аймаг), Тэнгэрийн тэмдэг (Дундговь аймаг) театр АССИТЕЖ Монгол Үндэсний төвийн гишүүнээр элсэж орсон.

2.УРАН БҮТЭЭЛЧДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

2022 онд АССИТЕЖ Монгол үндэсний төв нь

жил бүр зохион байгуулагддаг “АССИТЕЖ Гадеринг” хүүхэд залуучуудад зориулсан тайзны урлагийн олон улсын уулзалт чуулганд

тоглогдох тайзны уран бүтээлийн сонгон шалгаруулалтад анх удаа Монгол улсаас саналаа илгээв. Швед улсын Хэлсинбүрг хотод

зохион байгуулагдсан энэхүү чуулган нь соёлын цөөнх гэгдэх уугуул иргэдийн аж байдал, язгуур соёлыг хүүхэд залуучуудад танин мэдүүлэх, хадгалж хамгаалах сэдвийн

хүрээнд байсан ба Монгол улсыг төлөөлж Монголын язгуур урлагийн “Алтай” 2021-2022 оны амжилт ба ололтууд хамтлагийн уран бүтээл “Бийгээн биелэе” бүтээлийг (найруулагч Д.Ганпүрэв) илгээсэн.

Тус бүтээлд икэл хуур, Алтай ятга, уугуул иргэдийн эрэгтэй болон эмэгтэй хоолой, хархираа хөөмийг хамсран дуулсан байдаг нь

хамгийн тохиромжтой бүтээл байв.

Түүнчлэн Олон Улсын АССИТЕЖ-ийн “New

Generation Program” хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад Монгол улсаас төлөөлж залуу бүжигчин, хүүхдийн бүжгийн багш, хүүхдийн театрт жүжигчин байсан туршлагатай уран бүтээлч Э.Тэнүүнг санал болгож, өргөдөл илгээсэн.

2023-2024 ОН

**Монгол улсын хүүхэд
залуучуудын театрын
тогтвортой хөгжлийг
ДЭМЖИХ ЖИЛ**

2023-2024 ОН

Стратегийн зорилго 1. Хүртээмжтэй болгох

Хүүхдэд зориулсан уран бүтээлүүдийг олонд түгээх төсөл хөтөлбөрүүдийг санаачлах, дэмжих, санхүүжүүлэх боломжуудыг дотооддоо болон гадаадад эрэлхийлэх, хангах чиглэлийн хүрээнд хийгдсэн ажлууд

- Ахлах ангийн сурагчдад зориулсан драмын хөтөлбөр боловсруулж цаасан шувуу төслийг Бадмаараг ахлах сургуулийн 10-р ангийн сурагчдад зохион байгуулав.
- Next generation Mongolia хөтөлбөрийн хүрээнд 15 уран бүтээлчдийн 4 тайзны уран бүтээлийг хэрэгжүүлсэн
- Театрын боловсрол-Менторшип төсөл бичин төслийн сонгон шалгаруулалтад оролцож өсвөр үеийнхэнд зориулсан бичил театр бий болгох санаачтлга гаргав.
- Олон улсын фестивалийн сонгон шалгаруулалтад Орхон аймгийн ХЗТ, Бамбүү ХЗТ-ийн бүтээлүүдийг илгээж сонгон шалгаруулалтад оролцуулсан.



2023-2024 ОН

Стратегийн зорилго 2. Уран бүтээлчдийг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих

Шинээр гарч ирж буй болон ажиллаж буй тайзны уран бүтээлчид, байгууллагууд, багш сурган хүмүүжүүлэгчдийн чадвар чадамжийг дээшлүүлэхэд, залуу уран бүтээлчдийг үр дүнтэй бэлтгэж ажлын байрыг бий болгохыг зорино.

- Next generation Mongolia хөтөлбөрийн хүрээнд 15 уран бүтээлчдийг төсөл бичих багаар ажиллах, манлайлал зэрэг сургалтуудад хамруулж уран бүтээлийн төсөл бичих ойлголтыг нэмэгдүүлэв.
- Next generation хөтөлбөрийн хүрээнд Write Local. Play Global, Next generation international, Болон Пакистан, Дани, Өмнөд Африкийн уран бүтээлчидтэй уулзалт зохион байгуулсан
- БНСУ болон УХТ-аас зохион байгуулсан ODA хүүхэлдэйн жүжгийн сургалтад АССИТЕЖ үндэсний төвийн гишүүд болох Бамбүү театр, Саран хөхөө театр, NEXT generation хөтөлбөрийн оролцогчид оролцож хүүхэлдэйн театрын урлагийн талаар мэдлэгээ дээшлүүлэв.



2023-2024 ОН

Стратегийн зорилго 2. Уран бүтээлчдийг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих

Next generation Mongolia 2023

Уран бүтээлчдийг чадавхижуулах төсөл хэрэгжүүлж нийт 15 уран бүтээлчдийг хамруулж 4 сарын турш сургалт, хөтөлбөрт хамрагдан хөтөлбөрийн төгсгөлд 4 тайзны уран бүтээлийг олны хүртээл болгосон.

1.Network-Танилцах(09.02-09.30)

Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг хүүхэд залуучуудад зориулсан тайзны урлагийн байгууллагуудын үйл ажиллагаа, уран бүтээлтэй танилцаж, тайзны урлагийн суурь ойлголттой болсон.

2.Learn- Суралцах (10.01-10.30)

Олон улсын Асситежийн гишүүн орнуудын театруудын уран бүтээлүүдийг үзэж, уран бүтээлчидтэй танилцаж, олон улсын менторуудаас суралцаж уран бүтээлийн зохиол, судалгаа, төсөл, үйлдвэрлэлийн талаар ойлголттой болсон.

3.Research- Судлах (11.01-11.30)

Багт хуваагдан бичил судалгаа хийж, олон улсын тайзны уран бүтээлүүдээс туршлага судлан өөрсдийн бүтээх төслийн саналаа боловсруулав.

4.Create- Бүтээх (12.01-12.26)

Багт хуваагдан өөрсдийн хийсэн судалгаа болон төслөө бодит уран бүтээл болгож үзэгчдийн хүртээл болгосон.



“Бяцхан савар”
хүүхдийн жүжиг
(4-10 нас)



”Цаасан онгоц”
хүүхдийн
оролцоот
жүжиг (14+)



“Маргааш”
уншлагын жүжиг
(12-18 нас)



“Урсгал ус”
контемпорари
тайзны үзүүлбэр (Бүх
насныханд)

2023-2024 ОН

Стратегийн зорилго 3. Хамтын ажиллагаа

Хүүхэд залуучуудад зориулсан тайзны урлагийн уран бүтээлчид болон дэмжигчдийг нэгтгэж, тогтмол харилцаатай байж хамтран ажиллахад анхаарч, үндэсний хэмжээний эрүүл, нээлттэй, тогтвортой нетворкийг бий болгох


- 2023 оны 4 сард УХТ-д Асситеж Монгол Үндэсний төвийн гишүүдийн уулзалтыг зохион байгуулж 4 хүртэлх театрыг Асситеж Монгол Үндэсний төвийн гишүүнээр элсүүлсэн.
- NEXT generation Хөтөлбөрийн хүрээнд УХТ, Орхон аймгийн ХЗТ, МУЗ, НЕРКО хэвлэлийн газар, АГУЙ-02, Бамбүү театруудтай хамтын ажиллагааг хэрэгжүүлж, дэмжлэг авсан. Уг хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулж хамтрагч байгууллага хувь хүмүүст талархал илэрхийлэв.
- БНСУ, Денмарк, УЭЛС улс, Куба, Пакистан зэрэг улсын Асситеж төвүүдтэй харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн.
- Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Пакистан улсын Маас фестивальд Бамбүү театрын хамт олон Алим жүжгээрээ оролцсон нь анх удаа ХЗТ-ийн фестивалд оролцсон томоохон амжилт хэмээн үзэж байна.



Стратегийн зорилго 4. Олон нийтэд сурталчлах

Хүүхэд бүр урлагийн боловсрол авах эрхийг олон нийтийн сувгаар таниулж сурталчлахаас гадна эрхээ эдлэх боломжийг олон төрлийн арга хэмжээ, үйл ажиллагаануудаар дамжуулан бий болгох

- Тоонот- Хүүхэд залуучуудад зориулсан Өртөөчилсөн театрын фестивалийг зохион байгуулах төсөл бичин Соёлын яам болон бусад төслийн сонгон шалгаруулагдтад оролцов. .
- Next generation Mongolia хөтөлбөрийн хүрээнд “Монголын Хүүхэд залуучуудад зориулсан театрын хөгжлийн тогтвортой байдал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан
- Assitej Mongol үндэсний төвийн цахим хуудсуудыг бий болгож цаг тутмын мэдээллийг түгээсэн бөгөөл Assitejmongolia.org вэб сайтыг ашиглалтад оруулсан
- Next generation хөтөлбөрийн хэрэгжсэн төслүүдийн хүрээнд хүүхдүүдийн оролцоог хангах зорилго тавин, хүүхдийн оролцоот төслийг хэрэгжүүлсэн.



Олон улсын хамтийн ажиллагаа 2023 он

- **Assitej coffee session**

2023 оны 4 сард болсон цахим уулзалтад Асситеж Монгол Төвийн удирдах зөвлөлийн дарга А.Уянга, гүйцэтгэх захирал Т.Цэнд-Аюуш нар оролцож Асситеж олон улсын байгууллагын үйл ажиллагаа, цаашдын төлөвлөгөөний талаар ярилцсан.

- **Assitej Asia online meeting**

2024 оны 9 сарын 24нд болсон Асситеж Азийн орнуудын уулзалтад Асситеж Монгол Үндэсний төвийн гишүүд МУХТ, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, Баянхонгор Аймгийн Тэмүүжин театрын төлөөлөл, залуу уран бүтээлчид зэрэг 7 хүн оролцож Асситеж Монгол Төвийн үйл ажиллагаа, гишүүн театруудын үйл ажиллагааны мэдээлэл, хэрэгжүүлж байгаа төслүүдийг танилцуулж 2025 оны Азийн конгресс уулзалтын талаар мэдээллээ солилцлоо.

- **TYA director's workshop**

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын АССИТЕЖ Үндэсний төвөөс зохион байгуулсан Олон улсын хүүхдийн театрын найруулагч нарын туршлага солилцох уулзалтад Монгол улсыг төлөөлж Creative Bamboo театрын найруулагч, жүжигчин Төрмөнх оролцсон.

- **April festival**

АССИТЕЖ Монгол төвийн гишүүн болох "Бүтээлч Бамбүү" хүүхдийн театрын хамт олон Данийн вант улсын Jutland хотод зохиогдсон "April festival"-д амжилттай оролцсон.



Олон улсын хамтийн ажиллагаа

2024 он



“Next generation Mongolia 2023” хөтөлбөрийн оролцогч Г.Нарангоо “Next generation placement” бүтэн тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Нэгдсэн вант улсын (United Kingdom) ийн Уэльс Улсад(Wales) Arad goch театрын “Opening doors” хүүхэд залуучуудын театрын фестивалийн зохион байгуулагчаар 2 сарын турш ажилласан .



“Next generation Mongolia 2023” хөтөлбөрийн оролцогч Б.Дэлгэрмаа, О.Золжаргал нар 2024 оны 4-р сард Дани улсын Эсбьерг хотод болох "April festival"-д Дани улсын театрын холбооны тэтгэлэгээр эх орноо төлөөлөн оролцсон.



2024 оны 6 сард Куба улсад зохион байгуулагдах Next generation international-д NGP Mongolia 2023 хөтөлбөрийн төгсөгч Б.Золжаргал шалгаран оролцож туршлага хуримтлуулсан

Олон улсын Асситежийн уулзалтууд

21 дэх удаагийн АССИТЕЖ-ийн олон улсын конгресс уулзалт

5 сарын 24 - 6 сарын 1ний хооронд Куб улсын Хавана хотод болж өнгөрсөн 21 дэх удаагийн АССИТЕЖ-ийн олон улсын конгресс уулзалтад Монгол Улсаас АССИТЕЖ Монгол Үндэсний төвийн Удирдах Зөвлөлийн дарга А.Уянга болон Бамбүү театрын жүжигчин Б.Золжаргал нар Монголыг төлөөлж анх удаа оролцлоо.

60 гаруй орноос ирсэн 488 гадны зочид төлөөлөгчид хүрэлцэн ирсэн энэхүү олон улсын уулзалтад 25 гаруй хүүхэд залуучуудад зориулсан уран бүтээл, 65 воркшоп уулзалтууд зохион байгуулагдснаас гадна өнгөрсөн 3 жилээ дүгнэж, ирэх 3 жилийнхээ төлөвлөгөөг батлаж, шинэ Удирдах Зөвлөлөө сонгож маш амжилттайгаар зохион байгуулагдлаа.

АССИТЕЖ байгууллага нь 2022 оноос эхлэн Европын Холбооноос 750,000 ам.доллар, Дани Улсын Урлагийн сангаас 75 000 ам.долларын санхүүжилт 3 жилийн хугацаатай авч чадсанаараа үйл ажиллагаа нь улам өргөжиж, олон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү санхүүжилтээ үргэлжлүүлэн дахиад 4 жил авах хүсэлтээ илгээсэн байгаа бөгөөд авсан тохиолдолд хэрэгжүүлж буй төслүүдээ улам удаан хугацаанд хэрэгжүүлэх боломжтой болохоос гадна “Бүсийн хөгжлийн төлөвлөгөө” нэртэй урт хугацааны бүсийн үндэсний төвүүдээ дэмжих төсөл хөтөлбөр зарлагдаж хэрэгжихээр төлөвлөж байна.

Конгрессын хүрээнд Монгол дах Үндэсний төвөө төлөөлж Уянга оролцож бусад орнуудтай хэрхэн хамтран ажилласан, цаашдаа мөн хамтарч ажиллах боломжууд, тулгамдах асуудлуудын талаар бусад Азийн орнуудын төлөөлөгчтэй хамт хэлэлцүүлэгт оролцож цаашдын хамтын ажиллагаа болон Үндэсний төвөө таниулах ажил хийлээ.

Олон улсын энэхүү үйл ажиллагааны нэг чухал хэсэг болох хүүхэд залуучуудад зориулсан тайзны урлагийн ач холбогдол, үр нөлөө, хүртээмжийн хүрээнд хийгдсэн болон хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлууд танилцуулагдаж, бодлогын хүрээнд болон үндэстэн нийгэмд яагаад чухал болохыг мэргэжлийн судлаач нар олон талаас нь онцолж хэлэлцүүлэг өрнүүлж чадсан.



2023-2024 ОН

2023-2024 он нь Асситеж Монгол Үндэсний төвийн үйл ажиллагааг тогтвортой болгож, тогтмол хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрийг бий болгох зорилготой жил байсан бөгөөд үүний үр дүнд Next generation Mongolia 2023 хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн. Хүүхэд залуучуудын театрын урлагт сонирхолтой, цаашид энэ чиглэлээр ажиллах залуусыг дэмжих үүндээс мэргэжлийн болон мэргэжлийн бус 15 залуусыг төрөл бүрийн сургалт арга хэмжээгээр чадавхижуулж төслийн үр дүнд 4 тайзны уран бүтээлийг нийтийн хүртээл болгов. Мөн бид 2023-2024 онд олон улсын хөтөлбөрүүдэд 9 н уран бүтээлчийг хамруулсан сайхан амжилттай жил байв.

1

Хүртээмжтэй болгох чиглэлээр

Гишүүнчлэлдээ хувь хүмүүсээр нэмж, вэб сайт цахим орчинд мэдээллээ түгээсэн. Гэсэн хэдий ч цаашид хүртээмжтэй байлгах тал дээр илүү анхаарах ёстой гэсэн шийдвэрт хүрэв.

2

Уран бүтээлчдийг чадавхижуулах чиглэлээр

Олон улсын уулзалт хөтөлбөрүүдэд монгол уран бүтээлчдээ хамруулах боломжийг хайж, гадны уран бүтээлчидтэй холбоо харилцаа тогтоосон.

3

Хамтын ажиллагааны чиглэлээр

Монгол дах урлагийн байгууллагууд олон улсын байгууллагуудтай харилцаа тогтоосон. Дараагийн жилүүдэд хамтын ажиллагааг тогтвортой байлгах тал дээр анхаарах ёстой гэж дүгнэж байна.


4

Олон нийтэд суртачлах чиглэлээр

Олон нийтэд суртачлах чиглэлд хийсэн ажлын үр дүнг сайжруулах сар бүрийн сэтгүүл, мэдээллээр хангах ёстой хэмээн дүгнэж байна.

2024-2025 ОН

Уур амьсгалын
өөрчлөлтөд хүүхдийн
театрын оролцоог
нэмэгдүүлэх жил




2024-2025 ОН

Стратегийн зорилго 1. Хүртээмжтэй болгох

Хүүхдэд зориулсан уран бүтээлүүдийг олонд түгээх төсөл хөтөлбөрүүдийг санаачлах, дэмжих, санхүүжүүлэх боломжуудыг дотооддоо болон гадаадад эрэлхийлэх, хангах

- Асситеж Монгол Үндэсний төвийн гишүүнчлэлд хувь хүмүүс болон хувийн театруудаар нэмэгдүүлж чадсан. Рома театр, Про театр, Маппет театр, Нэг үүдэл ТББ г.м
- Монголдоо анх удаа хүүхэд залуучуудад зориулсан олон улсын театрын фестивалийг зохион байгуулах хамтын ажиллагааны гэрээ байгуулж 2026 оны 3-р сард зохион байгуулахаар төлөвлөж байна.
- “Wanderlust in Asia” хүүхэд залуучуудын театрын фестивалийн төслийг Недал, Индонези улсуудтай хамтран зохион байгуулахаар Асситеж олон улсын холбооны төслийн сонгон шалгаруулалтад илгээсэн бөгөөд шалгарч төслийн эхний санхүүжилтийг бүрдүүлэв.
- Уур амьсгалын өөрчлөлтөд хүүхэд залуучуудад зориулсан театрын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Next generation Mongolia хөтөлбөрийг 2 дах жилдээ зохион байгууллаа.



2024-2025 ОН

Стратегийн зорилго 2. Уран бүтээлчдийг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих

Шинээр гарч ирж буй болон ажиллаж буй тайзны уран бүтээлчид, байгууллагууд, багш сурган хүмүүжүүлэгчдийн чадвар чадамжийг дээшлүүлэхэд, залуу уран бүтээлчдийг үр дүнтэй бэлтгэж ажлын байрыг бий болгохыг зорино.

- Next generation Mongolia 2024 хөтөлбөрийн хүрээнд 15 уран бүтээлчдийг уур амьсгалын өөрчлөлт, хүүхдийн сэтгэл зүйг таних, жүжгийн зохиол бичих, найруулах зэрэг воркшопуудад хамруулсан бөгөөд төслийн үр дүнд 3 тайзны уран бүтээл олны хүртээл болсон.
- АНУ-н театрын мэргэжилтэн Claire тай хамтран /Devised theater/ буюу үйл явцад суурилсан театрын аргачлалын талаар воркшоп зохион байгуулж мэргэжлийн болон сонирхогч 15 оролцогчыг хамруулсан.
- Next generation Mongolia хөтөлбөрийн хүрээнд Write Local. Play Global, Next generation international холбооны уран бүтээлчидтэй цахим хичээл зохион байгуулж арга зүйн сургалтад хамруулсан.
- Олон улсын фестивалийн сонгон шалгаруулалтад Орхон аймгийн ХЗТ, Бамбүү ХЗТ-ийн уран бүтээлүүдийг илгээж сонгон шалгаруулалтад оролцуулсан.

Bamboo

About our teacher

Claire Derriennic



Claire Derriennic is a playwright and drama teacher from Washington DC, USA. Recently, Claire developed and performed Pen Pals, a play for ages 4-8, in Murcia, Spain. She is also the creator of Fishing for Stars, a play for ages 0-5 that will premiere at The Kennedy Center in Washington DC in 2026. With ten years of experience as a French instructor at an immersion summer camp, Claire recently earned her Master of Fine Arts in Theatre for Youth as well as a certification in theatre teaching.



2024-2025 ОН

Стратегийн зорилго 2. Уран бүтээлчдийг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих

Next generation Mongolia 2024

Уран бүтээлчдийг чадавхижуулах төсөл хэрэгжүүлж нийт 12 уран бүтээлчдийг хамруулж 3 сарын турш сургалт, хөтөлбөрт хамрагдан хөтөлбөрийн төгсгөлд 3 тайзны уран бүтээлийг олны хүртээл болгосон.

1-р үе: Танилцах (9.15-10.15)

Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг хүүхэд залуучуудад зориулсан тайзны урлагийн байгууллагуудын үйл ажиллагаа, уран бүтээлтэй танилцаж, тайзны урлагийн суурь ойлголттой болж уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэгээ дээшлүүлсэн.


Олон улсын Асситежийн гишүүн орнуудын театруудын төлөөлөгч, уран бүтээлчидтэй танилцаж, Монгол улсын менторуудаас суралцаж уран бүтээлийн судалгаа, төсөл, үйлдвэрлэлийн талаар ойлголттой болсон.

2-р үе: Судалгаа, Суралцах үе (10.15-11.15)

Багт хуваагдан бичил судалгаа хийж, олон улсын тайзны уран бүтээлүүдээс туршлага судлан өөрсдийн бүтээх төслийн саналаа боловсруулж, жүжгийн зохиолоо бичсэн.

3-р үе: Бүтээх үе (11.15-12.1)

Өөрсдийн хийсэн судалгаа болон төслөө бодит уран бүтээл болгож үзэгчдийн хүтээл болгов.



“Цаасан хот”
хувцасны зохисгүй
хэрэглээний талаар
хүүхдийн жүжиг (6-10
нас)



“Дууч шувуу” агаарын
бохирдлын талаар
хүүхдийн жүжиг (4-8
нас)



“Хүндэт Марвин”
далай болон усны
бохирдлын талаар
дуулалт жүжиг (4+
нас)

2024-2025 ОН

Стратегийн зорилго 3. Хамтын ажиллагаа

Хүүхэд залуучуудад зориулсан тайзны урлагийн уран бүтээлчид болон дэмжигчдийг нэгтгэж, тогтмол харилцаатай байж хамтран ажиллахад анхаарч, үндэсний хэмжээний эрүүл, нээлттэй, тогтвортой нетворкийг бий болгох

- Асситеж Монгол Үндэсний төвийн урилгаар Дани улсын Бангледет театр Бамбүү ХЗТ-тай хамтран Yes It's raining хүүхдийн жүжгийг олны хүртээл болгосон бөгөөд Next generation Mongolia 2024 хөтөлбөрийн оролцогчдод воркшоп хичээл зохион байгуулсан.
- Next generation Mongolia 2024 хөтөлбөрийн хүрээнд Climate Mongolia төвтэй хамтран уур амьсгалын өөрчлөлтийн талаар воркшоп зохион байгуулсан
- Непал, Индонези улсын үндэсний төвүүдтэй хамтран олон улсын театрын фестивал зохион байгуулах төслийг санаачлан хамтын ажиллагааг эхлүүлэв.
- Next generation Mongolia 2024 хүрээнд УХТ -аар зочилж Бяцхан хунтайж хүүхэлдэйн жүжиг үзэж театрын үйл ажиллаатай танилцав.
- БНСУ -н Unima хүүхэлдэйн театрын уран бүтээлчидтэй хамтран хүүхэлдэйн театрын урлагийн талаар сургалт цахим сургалтыг зохион байгуулав.



2024-2025 ОН

Стратегийн зорилго 4. Олон нийтэд сурталчлах

Хүүхэд бүр урлагийн боловсрол авах эрхийг олон нийтийн сувгаар таниулж сурталчлахаас гадна эрхээ эдлэх боломжийг олон төрлийн арга хэмжээ, үйл ажиллагаануудаар дамжуулан бий болгох

- Дэлхийн хүүхэлдэйн театрын өдрийн хүрээнд УХТ зохион байгуулсан хүүхэлдэйчдийн парадад оролцож хүүхэд залуучуудын театр хүүхэлдэйн театрын урлагийг олон нийтэд суртачлан таниулсан
- MDP продакшинтай хамтран “Асситеж Монгол үндэсний төвийн танилцуулга”, “Wanderlust” нүүдлийн театрын фестивалийн талаар нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.
- Монгол HD телевизийн өглөө хөтөлбөрт оролцож фестивалийн талаар танилцуулгыг хүргэв.




Олон улсын Асситежийн уулзалтууд

- **Bright generation**

Marseille, France-д зохион байгуулагдсан Bright generation уран бүтээлчдийн цугларалт уулзалтад цахимаар оролцож олон улсын жүжгүүдийг үзэж сонирхсон.

- **Олон улсын театрын фестивал**

Турк улсад зохион байгуулагдах олон улсын театрын фестивалд Орхон аймгийн ХЖТ -ийн бүтээл болох “Бүүвэй” хүүхэлдэйн жүжгийг илгээсэн.



Бидний амжилтууд

- Next generation Mongolia 2024 хөтөлбөрийг зохион байгуулахдаа уран бүтээлийн шатанд голчлон анхаарч Дани улсын Бангледет театр, БНСУ, АНУ, Румын улсын уран бүтээлчдээс арга зүйн зөвлөмж авсан. Ингэснээр бүтээлийн чанар, зохиолын агуулга илүү чанаржсан. 2023 онд зохиогдсон хөтөлбөрийн төгсөгчдөөс авсан санал асуулга дээр үндэслэн хугацааг 3 сар болгож уран бүтээлийн шатыг илүү чанартай болгоход анхаарч ажиллалаа. Энэ жил олон улсад зохиогдох уулзалт, фестивалийн зар бага байсан бөгөөд “Next generation international” хөтөлбөр 2026 онд зохион байгуулагдах үед шилдэг оролцогчынхоо материалыг илгээх юм.
- Асситеж олон улсын байгууллагаас зарласан бүс нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт Непал, Индонези улсуудтай хамтарсан төсөл бичиж шилдэг 2 төслийн нэгээр шалгарч эхний санхүүжилтийг бүрдүүлэв.
- Орхон, Булган аймгийн Засаг Даргын Тамгийн Газартай хамтран ажиллан Wanderlust Mongolia Festival-аа 2026 онд амжилттай зохион байгуулах ажилдаа орсон.



Wanderlust in Asia

A Co-funded Project by the Regional Cooperation Programme
of ASSITEJ International



Assitej Mongolia



Assitej Indonesia



Assitej Nepal



Уур амьсгалын өөрчлөлтөд хүүхдийн театрын оролцоог бодит болгоход хувь нэмэр оруулах, Монгол улсад анх удаа Хүүхэд залуучуудын театрын Фестивалийг зохион байгуулахаар зорьж ажилласан.

1

Хүртээмжтэй болгох чиглэлээр

Гишүүнчлэлдээ хувь хүмүүсээр нэмж, вэб сайт цахим орчинд мэдээллээ түгээсэн. Гэсэн хэдий ч цаашид хүртээмжтэй байлгах тал дээр илүү анхаарах ёстой гэсэн шийдвэрт хүрэв.

2

Уран бүтээлчдийг чадавхижуулах чиглэлээр

Олон улсын уулзалт хөтөлбөрүүдэд монгол уран бүтээлчдээ хамруулах боломжийг хайж, гадны уран бүтээлчидтэй холбоо харилцаа тогтоосон.

3

Хамтын ажиллагааны чиглэлээр

Монгол дах урлагийн байгууллагууд олон улсын байгууллагуудтай харилцаа тогтоосон. Дараагийн жилүүдэд хамтын ажиллагааг тогтвортой байлгах тал дээр анхаарах ёстой гэж дүгнэж байна.

4

Олон нийтэд суртачлах чиглэлээр

Олон нийтэд суртачлах чиглэлд хийсэн ажлын үр дүнг сайжруулах сар бүрийн сэтгүүл, мэдээллээр хангах ёстой хэмээн дүгнэж байна.



ASSITEJ MONGOLIA

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА